



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/16

Баянтал сум

Сумын Засаг даргын шагналын журмыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а, “к”, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын шагналын журмыг хавсралтад зааснаар шинэчлэн баталсугай.
2. Шагналын журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /В.Гантуяа/-д үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/75 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Г.АНХБАЯР

БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Сумын Засаг даргаас олгох шагналын төрөл, болзол, тавигдах шаардлага, шагналд нэр дэвшүүлэх, уламжлах, өргөн мэдүүлэх, түүнийг хүлээн авч судлах, шийдвэрлэх, шагналыг гардуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна

1.2 Сумын төрийн захиргаа, нийгэм эдийн засаг, хөдөө аж ахуй, соёл урлаг, боловсрол, эрүүл мэнд нийгмийн хамгаалал болон бусад салбарыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж, идэвх санаачлага гаргаж үр бүтээлтэй ажилласан ажилтан, албан хаагч иргэд байгууллага, хамт олныг энэ журмын дагуу шагнаж урамшуулна.

ХОЁР. ШАГНАЛЫН ТӨРӨЛ

2.1 Сумын Засаг даргаас олгох шагнал нь дараах төрлүүдтэй байна. Үүнд

2.1.1 Сумын “Аварга малчин” цол

2.1.2 Сумын “Алдарт уяач” цол

2.1.3 Сумын “Тэргүүний ажилтан”

2.1.4 Сумын “Тэргүүний ажилчин”

2.1.5 Сумын Засаг даргын “Жуух бичиг”

ГУРАВ. ШАГНАЛ ОЛГОХ БОЛЗОЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Сумын Засаг даргын шагналд тодорхойлогдож байгаа дор дурдсан болзол, шалгуурыг хангасан байна. Үүнд

3.1.1 Сумын “Аварга малчин өрх” цол Мал маллагааны арга ажиллагааг боловсронгуй болгох, малын үүлдэр угсааг сайжруулах, нутгийн шилмэл омог, бий болгох, малын ашиг шимийн гарц чанарыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өсгөх болон малгүй өрхийг малжуулах, мал сүргээ даатгалд хамруулах, малаа эрүүлжүүлэх, мал сүргээ тогтмол өсгөсөн малчдыг сумын “Аварга малчин өрх” тэмдэг үнэмлэх, үнэ бүхий зүйлээр шагнана.

3.1.2 Сумын “Алдарт уяач” цолыг доорх болзол хангасан уяач нарт олгоно. Сумын баяр наадамд уяж сойсон хурдан хүлэг морь нь түрүүлж айрагдаж Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8.5-д заасан болзол хангасан уяач нарт

3.1.3 Сумын “Тэргүүний ажилтан, ажилчин” Орон нутгийн бүтээн байгуулалтанд томоохон хөрөнгө оруулалт хийсэн төрийн захиргаа, урлаг, спорт, боловсрол, эрүүл мэнд салбарт онцгой амжилт гаргасан иргэний тухайн онд гаргасан амжилтыг тус тус хэлэлцэн

3.1.4 “Тэргүүний ажилтан, ажилтан”-аар шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

3.1.5 Сумын “Тэргүүний хамт олон” Сумын нийгэм эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, хамт олныг

тухайн жилийн “Тэргүүний хамт олон”-оор шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

3.1.6 “Тэргүүний хамт олон”-д нэр дэвшиж байгаа аж ахуй нэгж байгууллага нь татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй, төсвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн орчны тохижилт нь жишиг болохуйц, тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажилладаг, ард иргэдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн байна.

3.1.7 Сумын Засаг даргын “Жуух бичиг” Байгууллага салбар ой, бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн амжилт гаргаж хамт олноо хошуучлан тухайн салбартаа 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан хүмүүсийг сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнана.

ДӨРӨВ ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ ТОДОРХОЙЛОХ

4.1 Шагналд нэр дэвшигч нь Журмын гуравдугаар зүйлд заасан болзлыг хангасан байна.

4.2 Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулах санаачилгыг сум орон нутийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжээс гаргана.

4.3 Сумын Засаг даргын “Жуух бичиг”, “Тэргүүний ажилтан, ажилчин” шагналд нэр дэвшүүлэхээр тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд

4.3.1 Нэр дэвшигчийн анкет/ хүснэгт нэг/

4.3.2 Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт

4.3.3 Хамт олны хурлын тэмдэглэл

4.3.4 Тухайн шагналаар шагнуулахыг дэмжсэн харьяалах төрийн болон төрийн бус байгууллагын албан бичиг

4.4 “Тэргүүний хамт олон” шагналд нэр дэвшүүлж тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд

4.4.1 Байгууллагын товч танилцуулга

4.4.2 Байгууллагын тайлан уг тайланд шагналын шалгуур үзүүлэлт дурдсан асуудал байгууллагын гаргасан амжилт, ололтын талаар баталгаажуулсан байна.

4.4.3 Татвар нийгмийн даатгал болон холбогдох байгууллагын албан бичиг

4.4 Сумын “Аварга малчин”-аар шалгаруулахаар дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.4.1 Малчны товч анкет /Энэхүү шагналын журмын 2 дүгээр хавсралт маягтын дагуу/

4.4.2 Ажлын үзүүлэлт / Энэхүү шагналын журмын 4 дүгээр хавсралт маягтын дагуу/

4.4.3 Багийн Иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл

4.4.4 Багийн Засаг даргын хүсэлт

4.5 Үндэсний баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасан болзол хангасан уяачид Сумын “Алдарт уяач” цол олгуулах хүсэлтийг холбогдох баримт бичгийг бүрдүүлэн сумын Уяачдын холбооноос 01 дүгээр сарын 5-ны өдрийн доторх сумын Засаг даргын тамгын газар хүргүүлнэ.

4.6 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүд “Тэргүүний хамт олон”, “Тэргүүний ажилтан, ажилчин”-д нэр дэвшигчийн материалыг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

4.7 “Жуух бичиг” шагналд нэр дэвшигчийн материалыг тухайн тэмдэглэлт өдрөөс 10 хоногийн өмнө Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн байх шаардлагатай.

ТАВ. ШАГНАЛЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ, ОЛГОХ

5.1 Сумын Засаг даргын шагналд тодорхойлсон шагналын материалыг баримт бичгийн бүрдлийг холбогдох мэргэжилтэнгүүд шагналд нэр дэвшигчийн шагнуулах үндэслэл, тодорхойлолтыг хянаж үзэж дор дурдсан хугацаанд шагналын материалыг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлнэ. Үүнд

5.1.1 Сумын “Аварга малчин”, “Алдарт уяач”-д нэр дэвшигчдийн материалыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор

5.1.2”-д нэр дэвшигчийн материалыг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор

5.1.3”Жуух бичиг”-ээр шагнах асуудлыг тухай бүр

№	Шагналын нэр	Олгох шагналын хэмжээ	Жилд олгох хүний тоо
1	Сумын “Аварга малчин өрх” тэмдэг үнэмлэх	350,000 төгрөгийн үнэ бүхий зүйл	2
2	Сумын “Алдарт уяач” тэмдэг үнэмлэх	150,000 төгрөгийн үнэ бүхий зүйл	Болзол хангасан тохиолдолд
3	Сумын “Тэргүүний хамт олон”	250,000 төгрөгийн үнэ бүхий зүйл	1
4	Сумын “Тэргүүний ажилтан”	150,000 төгрөгийн үнэ бүхий зүйл	1
5	Сумын “Тэргүүний ажилчин”	150,000 төгрөгийн үнэ бүхий зүйл	1
6	Сумын Засаг даргын “Жуух бичиг”	50,000 төгрөгийн үнэ бүхий зүйл	10

5.2 Сумын “Аварга малчин өрх, Алдарт уяач” шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэнд гардуулна.

5.3 Сумын “Тэргүүний хамт олон” “Тэргүүний ажилтан, ажилчин” шагналыг сумын Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээн дээр гардуулна.

5.4 Сумын Засаг даргын шагналд дагалдах мөнгөн шагнал болон үнэ бүхий зүйлийн мөнгөний хэмжээ, олгох хүний тоо

5.5 Шагналд зарцуулагдах хөрөнгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулна.

ЗУРГАА БУСАД

6.1 Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөн болон сумын Засаг даргын шагналд тодорхойлж ирүүлсэн шагналын материалуудыг буцаан хүргүүлэх болон шагнагдагсдын материалыг оны эцэст архивт хүлээлгэн өгөх ажлыг дотоод ажил хариуцсан мэргэжилтэн хариуцна.

**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ
ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ**

1. Овог нэр:
2. Төрсөн огноо:
3. Регистрийн дугаар:
4. Хүйс:
5. Төрсөн аймаг, сум:
6. Оршин суугаа газрын хаяг:
7. Боловсрол мэргэжил :
8. Ажил эрхлэлтийн байдал:

Ажлын газрын нэр	Хугацаа /оноор/	Эрхэлсэн ажил

8. Ажилласан хугацаа:

Нийт..... жил үүнээс. Говьсүмбэр аймагт Баянтал суманджил тухайн салбарт жил тухайн хамт олны дотор ... жил

9. Шагнагдсан байдал:

10. Нэр дэвшиж байгаа шагналын төрөл:

11. Шагнуулах үндэслэл:

12. Утасны дугаар:

"СУМЫН АВАРГА МАЛЧИН"-Д ТОДОРХОЙЛЖ
БАЙГАА МАЛЧНЫ ТОВЧ АНКЕТ

.....он сар..... өдөр

1.	Сум, дүүрэг, баг, хорооны нэр		Цээж зураг 4*3
2.	Ургийн овог		
3.	Эцгийн /эх/ нэр		
4.	Нэр		
5.	Төрсөн он, нас, хүйс		
6.	Боловсрол		
7.	Ам бүлийн гишүүдийн тоо		
8.	Улсад ажилласан жил		
9.	Үүнээс малчнаар ажилласан жил		
10.	Төр, засгаас авсан шагнал, огноо		

---oOo---

"СУМЫН АВАРГА МАЛЧИН"- Д ТОДОРХОЙЛЖ БАЙГАА.....СУМЫН
МАЛЧИН.....НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

.....он.....сар.....өдөр

Үзүүлэлт	Малын төрөл	Онууд		
		.. он	.. он	.. он
Нэг. Малын төрөл, тоо				
1. Оны эхний мал /бодод шилжүүлснээр /	Бүгд			
2. Оны эхний мал Үүнээс:	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
3. Хээлтэгч Үүнээс:	Бүгд			
	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
4. Хээлтүүлэгч Үүнээс:	Бүгд			
	Буур			
	Азрага			
	Бух			
	Хуц			
	Ухна			
5. Бойжуулсан төл	Бүгд			
	Ботго			
	Унага			
	Тугал			
	Хурга			
	Ишиг			
6. Үржилд худалдсан мал	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
7. Малжуулахад өгсөн мал	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
8. Зүй бусаар хорогдсон мал	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			

	Хонь			
	Ямаа			
9. Зах зээлд борлуулсан мал	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
10. Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
11. Оны эцэст тоологдсон мал	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
12. Хээлтүүлэгчийн тохироо	Буур			
	Азрага			
	Бух			
	Хуц			
	Ухна			
13. Хээлтэгчийн эзлэх хувийн жин	Бод - 35			
	Бог - 50			
Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал				
14. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг, нядлагын жингээр/ Үүнээс:	Бүгд			
	Тэмээний мах			
	Адууны мах			
	Үхрийн мах			
	Хонины мах			
	Ямааны мах			
15. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	Тэмээний ноос, кг			
	Хонины ноос, кг			
	Ямааны ноолуур, кг			
	Мах үйлдвэрлэл, кг			
	Сүү, литр			
16. Бүтээгдэхүүнээс олсон нийт орлого /мянган төгрөг/ Үүнээс:	Бүгд			
	Мал борлуулснаас			
	Махнаас			
	Ноос, ноолуураас			
	Сүүнээс			
	Арьс, ширнээс			
	Бусад			
17. Өөрийн хүчээр бэлтгэсэн тэжээл, тн	Өвс			
	Гар тэжээл			
	Хужир, шүү			
18. Хашаа хороо	Хашааны тоо			
	Багтаамж /хонин тол/			
19. Худаг уст цэг	Худгийн тоо			
	Хүчин чадал л./сек			

20. Татвар төлөлт	ЭМД-ын шимтгэл	Төгрөгөөр			
	НД-ын шимтгэл	Төгрөгөөр			
	Бусад автомашин	Төгрөгөөр			
21. Малын даатгал / МИД /		Малын тоо			
		Төлсөн хураамж			

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна.

----- сумын ----- багийн

Засаг дарга ----- /...../

"СУМЫН АВАРГА МАЛЧИН"- Д ТОДОРХОЙЛЖ БАЙГАА.....СУМЫН
МАЛЧИН.....НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

№	Баталгаа гаргасан байгууллага албан тушаалтан	Баталгаажуулах үзүүлэлт	Баталгааны материалын он, сар, өдөр, дугаар	Гарын үсэг тэмдэг
1	Сумын мал эмнэлэг үржлийн тасаг	-Малын индексжүүлсэн даатгалд малаа хамруулж, малчин өрхийн гишүүд холбогдох хууль тогтоомжийн дугуу эрүүл, мэндийн даатгал нийгмийн даатгалын шимтгэл төлөх -Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхдээ залуу малчин шинээр мал маллаж байгаа иргэн, өрхийг малжуулсан байх -Сүүлийн 3 жил дараалан малын зүй бус хорогдол гаргаагүй, бодод шилжүүлснээр 70-гаас доошгүй малтай эсэх -Сүрэгт эзлэх хээлтэгч малын тоо бодод 45, богт 30-аас доошгүй -Сүүлийн 3 жил оны эхний хээлтэгчээс 100 хувь бойжуулсан байх		
2	Багийн Засаг дарга	-Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхдээ залуу малчин шинээр мал маллаж байгаа иргэн, өрхийг малжуулсан байх -Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэж хөдөөд ядуурлыг буурлахал онцгой хувь нэмэр оруулсан байх -		
3	Сумын мал эмнэлэг үржлийн тасаг	-Удам гарвал, ашиг шим өндөртэй малыг үржилд ашигладаг мал эмнэлэг үржлийн тасгийн бүртгэлд бүртгэлтэй байх -Ашиг шим өндөр өсвөр 8 хүртэл толгой үржлийн малыг иргэдэд жил бүр борлуулсан байх -Мал эмнэлгийн үйлчилгээнд тогтмол хамрагдаж санаачлага гаргаж, малаа тогтоосон хургацаанд бэлэн байлгах		

Баталгаажуулсан

Багийн Засаг дарга /

/